

ШИЛЖИЛТИЙН ҮЕИЙН МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖЛИЙН ЗАРИМ ОНЦЛОГ

МУИС, ОУХС-ийн багш
Д. Мөнхтуяа

XX-р зууны төгсгөл нь жинхэнэ утгаараа дэлхийн эдийн засгийн глобалчлал эрчимжиж эхэлсэн үе боллоо. Өөрөөр хэлбэл, харилцан хамаарал, нэгдэх үйл явц улам бүр түргэсэж эдийн засгийн интеграци нь хэний ч төсөөлөөгүй хэмжээнд хүрсэн ба бүс нутгаас хальж тив дамжин явагдах болжээ. Үүний жишээ бол 1999 оны 6-р сард болсон Баруун Европ, Латин Америкийн улсууд оролцсон Рио-де-Жанейро дахь уулзалтаас гаргасан Баруун Европ-Латин Америкийн чөлөөт худалдааны бүс байгуулах тухай шийдвэр, 2000 оны 4-р сард Канадын Квебек хотноо болсон Америкийн орнуудын дээд хэмжээний уулзалтаас гаргасан Нийт Америкийн чөлөөт худалдааны бүс байгуулах шийдвэр юм.

Эдийн засагч, судлаачдын үзэж байгаагаар өнөөгийн глобалчлагдаж буй дэлхийн эдийн засгийн гол онцлог нь дэд системүүд үүсэн төлөвшиж байгаа явдал билээ. Үүнд:

- Засгийн газар хоорондын харилцан үйлчлэлийн орчинд
- Үндэстэн дамнасан корпорациудын үйл ажиллагааны орчинд
- Засгийн газраас үл хамааран бодлого боловсруулагч ОУ-ын эдийн засгийн болоод бүс нутгийн интеграцийн байгууллагуудын орчинд

1. Уламжлал ёсоор, түүхийн бүхий л цаг үед төр засгууд эдийн засгийн үйл ажиллагааны үндсэн субъект болсоор ирсэн ба мөн түүнчлэн дэлхийн аж ахуйн системийг тэрхүү үндэсний эдийн засгууд л бүрдүүлдэг байлаа. Гэтэл өнөөдөр тусгаар улсын дэлхийн эдийн засаг дахь нөлөөлөл багассаар байгаа бөгөөд нөгөө хоёр дэд системдээ зарим талаар байраа тавьж өгч байна.

2. Энэ дэд систем нь өөрийн хүчин чадал, цар хүрээгээрээ үндэсний эдийн засгаас хавьгүй илүү болоод байна. 1970 онд гэхэд л НҮБ-ын мэдээлснээр дэлхий дээр 7,3 мянган үндэстэн дамнасан корпораци /TNC/ 24000 салбартай байсан бол 1990-ээд оны дунд гэхэд энэ тоо эрс өсч 40000 үндэстэн дамнасан корпораци, тэдгээрийн 250000 салаа мөчир дэлхийн эдийн засаг, улс төрийн амьдралыг хяналтандаа байлгаж, хөрөнгийн хөдөлгөөн, эрх ашгийн хэлбэлзэл, тусгаар улс орнуудын эдийн засаг, улс төрийн байдлыг тодорхойлж байна гэхэд хилсдэхгүй байх. Тэдэнд дэлхийн нийт бүтээгдэхүүний 1/4, дэлхийн нийт худалдааны эргэлтийн 40% нь ногддог.

3. Дэлхийн эдийн засаг дахь олон улсын эдийн засгийн байгууллагуудын байр суурь сүүлийн жилүүдэд эрс нэмэгдэж байгаа бөгөөд үйл ажиллагааны цар хүрээ нь нэмэгдээд зогсохгүй, тэд олон улсын эдийн засгийн харилцаанд биеэ даасан бүрэн эрхт субъект болон

оролцож, ОУ-ын эдийн засгийн харилцаанд чухал шийдвэр гаргахад улам бүр нөлөөтэй болсоор байна.

Глобалчлал нь дэлхийн эдийн засгийн системийн бүтцийг өөрчлөөд зогсохгүй тээвэр, харилцаа, холбоо зэргийг нэгтгэж чадсан. Тодруулбал, мэдээллийн технологийн ололт нь тээврийн үйлчилгээ, харилцаа холбооны үнийг бууруулсан ба бизнесийн үйл ажиллагаа болоод хүмүүс хоорондын харилцаанд таатай байдлыг бий болгосон. Энэ мэт глобалчлалын сайн талуудыг дурдаад барахгүй, Гэтэл аливаа юмс үзэгдэл сайн, муу талтай байдагчлан глобалчлал нь урьд өмнө байгаагүй сөрөг үр дагавруудыг үүсгэж байна. Тухайлбал, ДОХ, экологийн асуудал, терроризм гэх мэт.

Дээр өгүүлсэнчлэн глобалчлал нь нийгэм, эдийн засаг, улс төрийн бүхий л салбарт өөрчлөлт гаргаж байна. Тэр дундаа дэд систем буй болж байгаа явдал нь улс орнуудын нийгэм, эдийн засаг, улс төрийн биеэ даасан байдлыг алдагдуулж байгаа бөгөөд том гүрнүүдийн хувьд энэ нь **харилцан хараат** /interdependent/ байдлаар үйлчилж байгаа бол манайх шиг жижиг орны хувьд гадаад ертөнцөөс бүрэн хараат болох аюулд хүргэж ч магадгүй болоод байна. Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалд ч тодорхой заасан. Тодруулбал, *Эдийн засгийн аюулгүй байдал гэж дотоод нөөц бололцоогоо ашиглан нөхөн үйлдвэрлэл явуулах, ард түмнийхээ хэрэгцээг хангах, тусгаар тогтносон байдлаа бэхжүүлэх эдийн засгийн чадавхитай байх, шаардлагатай нөхцөлд улс орноо тодорхой хугацаагаар тэтгэж чадах эдийн засгийн бүтэц бүрдсэн байдлыг хэлнэ. Эдийн засгийн аюулгүй байдал нь Монгол улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдлын тулгуур үндэс мөн.*

Эндээс глобалчлалын энэ үед улс орон гадаад ертөнцөөс бүрэн тусгаар байх боломжгүй боловч **бүрэн** хараат болохгүйн тулд жижиг эдийн засаг яах ёстой вэ? гэсэн асуулт урган гарна. Энэ тохиолдолд миний бодлоор аливаа эдийн засаг өөрийгөө тэтгэх чадвар бүхий байх явдал нь хамгаас чухал гэж үзээд дотоодын эдийн засгийн байдалд цомхон анализ хийх зорилгоор зарим нэг тоо баримтуудыг авч үзье. /Сангийн яамны мэдээ/

Монгол улс эдийн засгийн хөгжлийн цоо шинэ шалгуурыг давсан ч богино хугацаанд чамлахааргүй амжилтанд хүрсэн. Тодруулбал, Монгол улс зах зээлийн харилцаанд шилжиж эхэлсэн 1990-д оноос хойш нийгэм, эдийн засагт их хэмжээний өөрчлөлт гарсан. Эдийн засгийн уналтын энэ үед макро эдийн засгийн тогтворжуулах бодлого явуулсан ба 1994 оноос эдийн засгийн уналт тогтворжиж эхэлсэн. ДНБ-д 1994 оноос өсөлт ажиглагдаж эхэлсэн /хүснэгт 1/, мөнгөний хатуу бодлого явуулсны дүнд инфляци буурч 1992 онд 325.5 байснаа 1997 онд 17.5, 1998 онд 9.4, 1999 онд 7.6 хувь болов.

Мөн хугацаанд өмч хувьчлах үйл ажиллагаа эрчимжсэнээр эдийн засаг дахь хувийн хэвшлийн цар хүрээ өсч худалдаа, үйлчилгээний салбаруудад 90 хувь, ХАА-д 78.8 хувийг эзлэх болсон. Улсын төсвийн орлогын ДНБ-д эзлэх хувь 1994-1999 онд 30 орчим хувьд тогтвортой

байна. Харин ДНБ-д нийт тэнцлийн эзлэх хувь 1994 оноос хойш буурч байгаа.

Нөгөө талаас зарим нэг тоон үзүүлэлт нь улс орныхоо хувь заяаны төлөө санаа зовнидог хэн бүхэнд нэгийг бодогдуулахаар байна.

Хүснэгт 1. 1995-2001 оны ДНБ, нэг хүнд ноогдох ДНБ-ий өсөлт

Үзүүлэлт	1995	1996	1997	1998	1999	2000	2001
ДНБ-ний өсөлт / % /	6,3	2,4	4,0	3,5	3,5	1,1	1,1
Нэг хүнд ноогдох ДНБ-ний өсөлт /ээрэгцүүлэх үнээр/	4,7	0,8	2,6	2,1	1,9	0,5	-

Энэхүү үзүүлэлтээс үзвэл дотоодын нийт бүтээгдэхүүний өсөлт сүүлийн жилүүдэд удааширснаас 2000 онд өсөлт 1.1 хүртэл буурсан нь олон хүчин зүйлсийн нөлөө байж болох хэдий ч сүүлийн жилүүдэд удаа дараа тохиосон байгалийн гамшигт үзэгдлүүд үндсэн шалтгааны нэг болсон. Эндээс эдийн засгийн системд эзлэх ХАА-н салбарын хувь хэмжээ болон тус салбарын эрсдэлийг хэрхэн бууруулах тал дээр анхаарч, шийдвэрлэх хэрэгтэй гэдэг нь харагдаж байна.

Хүснэгт 2. Хөгжлийн албан ёсны тусламж /ХАЁТ/

Үзүүлэлт	1995	1996	1997	1998	1999	2000	2001
ХАЁТ-ийн ДНБ-д эзлэх хувь	25	18	18	25	21	24	17
Нэг хүнд ноогдох ХАЁТ / US \$ /	77	99	90	113	84	81	67

Гадаадын зээл тусламж нь эдийн засгийн хөгжлийг хангахад чухал үүрэгтэй хүчин зүйл яах аргагүй мөн ч манай улсын эдийн засгийн хувьд гадаадын зээл тусламжаас хүчтэй хамааралтай, хамаат байдалд орчихоод байгааг хэлэхэд хатуу ч гэсэн үнэн юм.

1991-2001 оны хооронд Монголд үзүүлсэн ХАЁТ бараг 1.9 тэрбум ам.доллартай тэнцэж байгаа нь 2 сая 500 мянгахан хүн амтай орны хувьд маш өндөр тоо юм.

ХАЁТ-ийн ДНБ-д эзлэх хувиараа Монгол улс дэлхийн улс орнуудын зээл тусламжаас хараат байдлаараа Мозамбик /28.2/, Никарагуа /28.1/, Малави /24.4/, Лаосын /23.0/ дараагаар 5-р байранд 20.6 хувьтайгаар тэргүүлж явна.

Хүснэгт 3. Гадаад өр

Үзүүлэлт	1998	1999	2000	2001
Улсын болон улсын оролцоотой баталгаажсан өр	753	850	854	912
ДНБ-д эзлэх хувь	77,4	93,9	88,0	80,7
Улсын болон улсын оролцоотой баталгаажсан гадаад өрийн өнөөгийн үнэ		571	558	
ДНБ-д эзлэх хувь		63	57,5	

Дээр бичсэн байдал улсын гадаад өрийн асуудалд ч мөн адил байгааг харж болно. Энэ байдал цааш үргэлжилбэл юу болохыг хэлэх нь илүүц биз. Зөвхөн үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалын 5-34-7-д заасан бусад улс буюу олон улсын байгууллагад өртэй болж дарамт шахалт, хараат байдалд орох гэсэн заалтыг л дурьдахад хангалттай болов уу.

Хүснэгт 4. Хөрөнгө оруулалтын бүтэц

Хөрөнгө оруулалтын хэлбэр	1995	1996	1997	1998	1999	2000
Гадаадын шууд хөрөнгө оруулалт	0,8	1,7	2,0	2,1	3,5	4,2
Дотоодын хөрөнгө оруулалт	15,7	20,3	20,7	23,7	25,6	24,7

Шилжилтийн эдийн засагтай, дотоодын хуримтлал муутай манай эдийн засгийн хувьд гадны хөрөнгө оруулалтыг татах нь тун чухал. Хүснэгтээс үзэхэд манай улс одоогоор хөрөнгө оруулалтын санхүүжилтээ гадаадын хувийн хөрөнгөд бус харин зээл тусламжинд тулгуурлаж иржээ. Гадаадын хөрөнгө оруулалтыг татах зорилгоор манай засгийн газар их зүйл хийж байгаа боловч ДНБ-д эзлэх хувийн жин дөнгөж 4 хувь байгаа нь манайх явуулж буй бодлогоо эргэж харах хэрэгтэй гэдгийг илрэл биз ээ.

Ер нь байгалийн арвин баялаг, нөөцтэй л биш бол гадаадын шууд хөрөнгө оруулагчид эдийн засгийн өсөлтийн сөрөг буюу доогуур үзүүлэлттэй эдийн засагт том хэмжээний хөрөнгө оруулдаггүй билээ.

Энэ мэт үзүүлэлт, тоо баримтаас үзвэл манай эдийн засагт бага боловч өсөлт байгаа хэдий ч анхаарах, нэн даруй арга хэмжээ авах хийгээд өөрчлөн шинэчлэх шаардлагатай зүйлс их байна. Тухайлбал, эдийн засгийн бүтэц, өр, зээл тусламжийн асуудал, гадаадын хөрөнгө оруулалтыг хэрхэн татах гэх мэт.

Иймд эдгээр асуудлуудыг хэрхэн шийдвэрлэх тал дээр эрдэмтэн, судлаачид маань өргөн цар хүрээтэй өөрийн орны онцлог байдлын судалгааг хийж арга хэмжээ авах цаг нь болжээ гэж үзэж байна. Өөрөөр хэлбэл, энэ богино хугацаанд олж авсан байдлаа хадгалах, хөгжүүлэхэд эрдэмтэн судлаачдын оролцоо маш чухал юм.

Ингээд миний бие зарим санал бодлоо товч тодруулъя.

1. ТТЭЗ-ийн тогтолцоо задарч зах зээлийн эдийн засгийн тогтолцоонд шилжсэнээр бид эдийн засаг дахь төрийн оролцоог хэт үгүйсгэж байна. Гэтэл бусад өндөр хөгжилтэй, бидний жишээ болгох дуртай орнуудын эдийн засгийн хөгжлийн загвараас харахад /шинээр аж үйлдвэржсэн орнууд/ төрийн оролцоо тэнд маш чухал үүрэг гүйцэтгэсэн. Харин эдийн засаг өсөхийн хэрээр төрийн оролцоо аяндаа багассан байна. Нөгөө талаас, макро эдийн засгийн онолын үүднээс үзсэн ч туйлын ойлголтоос нэгэнт татгалзсан. Өөрөөр хэлбэл, аливаа эдийн засагт төрийн зохистой оролцоо зайлшгүй бөгөөд эдийн засгийн өсөлтийг хангах макро

эдийн засгийн бодлогыг боловсруулж, хэрэгжүүлэхэд засгийн газар чухал үүрэг гүйцэтгэнэ.

2. Дийлэнх эдийн засагчид өнөөдөр ямар нэг протекционист бодлого явуулах боломжгүй, үр дүнгүй гэж үзэж байна. Миний бодлоор манайх жижиг эдийн засаг гэдгээ бодолцвол зарим нэг салбарт протекционист бодлого явуулах нь зүйтэй болов уу. Тодруулбал, бид урьд гурилаар л гэхэд дотоодын хэрэгцээг хангаад зогсохгүй хуучнаар ЗХУ-д экспортлодог байсныг санахад илүүдэхгүй биз дээ.

3. Эдийн засгийн бодит өсөлтийг хангах нэг хүчин зүйл бол үйлдвэрлэл

гэдэг нь нэгэнт нотлогдсон зүйл байх. Гэхдээ бидний мөрөөддөгчлөн гэнэт нэгэн сайхан өдөр том том үйлдвэрийн газрууд байгуулагдахгүй. Иймд нэн тэргүүнд уламжлалт ХАА, МАА-гаа техникжүүлэх, биотехнологи нэвтрүүлж болох ба ингэснээр эдгээр салбарууд дахь байгалийн шууд нөлөөг /ган, зуд/ бууруулж болмоор.

4. Зарим улс орнууд хөгжил нь гадаадын хөрөнгө оруулалтыг хэр зэрэг татахаас шалтгаалдаг хэмээн үзсээр байна. Гэвч бодит байдал дээр гадаадын шууд хөрөнгө оруулалт нь ихэвчлэн нэгэнт бий болсон өсөлтөд суурилахаас ирээдүйн өсөлтөд найддаггүй. Эндээс хөрөнгө оруулалтыг татахын тулд засгийн газар эхний үед ирээдүйтэй салбарын хөгжих эхний суурь нөхцлийг бүрдүүлэх шаардлагатай байна.

5. Манай улс гадаадын зээл тусламжийг хангалттай хүртэж буй ч түүнийг зохистой зарцуулаагүйгээс өнөөдөр хараат байдалд орчихоод байна. Иймд зээл тусламжийн зарцуулалт болоод хяналтын тал дээр сайтар боловсруулсан нийгэм, эдийн засгийн бодлогоор зохицуулалт хийх нь зүйтэй.

6. Эцэст нь эрдэмтэн, судлаачид өөрсдийн судалгаа шинжилгээний ажлыг нэгтгэх шаардлага зүй ёсоор урган гарч байна. Учир нь аливаа бодлого шийдвэрийн үр дүн нь бодитой байх нөхцөл нь суурь судалгаа сайн хийгдсэн байх явдал билээ. Гэтэл манай судлаачдын хийсэн судалгаа нэгтгэн боловсруулагддаггүйгээс төр засгийн бодлогод тусгал олох боломж муутай байдаг юм шиг санагддаг. Өөрөөр хэлбэл, ОУЭЗБайгууллагууд манай улсад бусад бүх орнуудтай ижил нөхцөл, шаардлага тавих нөхцлийг бид өөрсдөө бүрдүүлж байна. Энэ бүх байдал нь манай эдийн засгийг гаднаас хэт хараат болгоход түлхэж буй хүчин зүйлс юм гэж үзэж болно.

Ингээд глобалчлалын эрин үед улс орныхоо эдийн засгийн бие даасан байдлыг хадгалах асуудал маш чухал гэдгийг тэр дундаа эдийн засгийн хувьд гаднаас бүрэн хараат болохгүйн тулд эдийн засгийн чадавхийг дээшлүүлэх шаардлагатай хийгээд үүнийг зөвхөн Монголд тохирсон, Монголын эдийн засгийн хөгжлийн загвараар хэрэгжүүлэх боломжтой юм гэдгийг тэмдэглэмээр санагдана.

Specifics of the world economy in the age of Globalization is formation of infra systems. These systems bring down walls of political and economic independence of the nations and threatens to set interdependence amongst superpowers but menace countries like Mongolia to loose their complete independence. Though it is understandable that countries could not exist on their own during globalization era but it is vital that a country should have effective, continuous growing economy. Micro analyses are made on the Mongolian economic figures.